

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ХЭРЭГЖИЛТ

2026 оны 05 дугаар сарын 29

Улаанбаатар хот

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөрийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2025 он	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)		
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил							
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18	19
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО																		
Салбарын үр дүн: Хотын эдийн засгийн суурийг бэхжүүлж, төсвийн бус эх үүсвэрээр хөрөнгө оруулалтыг бүрдүүлэн төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжинэ.																		
Зорилтын үр дүн: 3.4. Улаанбаатар хотын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, жуулчдын ая тухтай аялах, зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.																		
476			1	Аялал жуулчлалын мэдээлэл сурталчилгааны төвийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.	2025-2028			724.0				724.0	Шинээр байгуулсан мэдээлэл сурталчилгааны төв, тоо	8	9	125.3	Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилготой жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг Жанжин Д.Сүхбаатарын талбай, Төв шуудан, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудал, ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах "Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төв", болон "Тэрэлж Монгол өлө", "Хонхор тосгон Монгол өлө", "Сөүлийн гудамж Монгол өлө" "Урухан" брэндийн гэр мэдээллийн төв зэрэг нийт 8 байршилд тогтмол болон улирлын чанартай ажиллуулж байна. Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд "Чойжин" жуулчны гэр мэдээллийн төвтэй хамтран ажиллах санамж бичиг байгуулан үйл ажиллагаагаа өргөжүүлж, мөн Жуулчны гудамжид байрлах "Урт цагаан" үйлчилгээний төвийн нэг давхарт жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг шинээр байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.	100
477			2	"Улаанбаатар өвлийн наадам" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028			627.0				627.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	13000	14000	195.2	Улаанбаатар хотод өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, үндэсний тоглоом наадгай болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 14 дэх удаагийн "Улаанбаатарын өвлийн наадам" арга хэмжээг "Скай резорт" цанын баазад 2026 оны 01 дүгээр сарын 31, 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулав. "Улаанбаатар өвлийн наадам" арга хэмжээний хүрээнд Мөсөн сурын олон улсын аварга шалгаруулах тэмцээн, Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээн, Параглайдингийн (уулын шүхэр) Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Снөүбоардын Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Уулын цанын Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, Кёрлингийн Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээн, "Grand tour winter cup 2026" аялал жуулчлалын салбарын оюутнууд дундах Буухиа тэмцээн зэрэг 7 төрлийн уралдаан тэмцээнд ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улс, Бүгд найрамдах Халимаг улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгурын ӨЗО, БНКазахстан Улс, АНУ зэрэг улсаас 46, Монгол Улсын 21 аймаг болон Улаанбаатар хотоос 1500 гаруй хүн оролцоо.Арга хэмжээний үеэр иргэд, сонирхогчдын дунд мөсөн хана авиралтын тэмцээн зохион байгуулж, мөн параглайдингийн үзүүлбэр, шувуулахуйн үзүүлбэр, танилцуулга, банхар нохдын үзүүлбэр, танилцуулга, цана чарганы үйлчилгээ, хоол ундны үйлчилгээ, цаа буга, морь, тэмээ унах үйлчилгээг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 15,000 гаруй хүн үзэж сонирхлоо.	100
478			3	"Улаанбаатар" явган алхалтын фестиваль зохион байгуулна.	2025-2028			507.5				507.5	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	1150	1200	34.1	Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах зорилгоор Монголын явган алхалтын холбоотой хамтран "Улаанбаатарын өвлийн явган алхалтын фестиваль-2026" арга хэмжээг 2026 оны 03 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд Горхи-тэрэлжийн байгалийн цогцолборт газарт байрлах "Чингис 21" жуулчны баазад зохион байгууллаа. Фестивальд АНУ, Нидерланд Улс (Голланд), БНЧУ, БНСУ, БНХАУ зэрэг 5 улсаас 50 гаруй алханч, "Монголын явган алхалтын холбоо"-ны салбар холбоод 21 аймаг, нийслэлийн дүүргүүдийн төлөөлөгчид, явган алхалтын клубүүдийн нийт 1200 гаруй алханчид оролцов. Арга хэмжээний үеэр олон улсын стандартын дагуу тэмдэг, тэмдэглэгээ бүрэн байршуулж тохижуулсан "Чингис-21" явган алхалтын замын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, оролцогчид шинэ маршрутаар 5 км явган алхалт хийж, мөн оролцогчдын дунд мөсөн сурын тэмцээн, олс таталтын тэмцээн зохион байгууллаа.	100

479	3.4.1.Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ	4	"Бүргэдийн баяр" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028		239.0						239.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	12000	13000	93.3	Казах түмний ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, бүргэдээр ан хийх дахин давтагдашгүй өвөрмөц соёлоор дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, өвлийн улиралд Улаанбаатар хотод зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор "Бүргэдийн баяр-2026" арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд "Чингис хааны хүрээ" аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулна."Бүргэдийн баяр-2026" арга хэмжээнд Бүгд Найрамдах Казахстан Улсаас 7, Бүгд Найрамдах Киргиз Улсаас 2, Оросын Холбооны Улсаас 1, Испанийн Хаант Улсаас 3, Унгар улсаас 1, Баян-Өлгий аймгаас 21, Төв аймгаас 1, Сэлэнгэ аймгаас 1 нийт 37 бүргэдийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн оролцлоо. Арга хэмжээний үеэр бүргэдтэй парад, бүргэдүүдийг танилцуулж алдаршуулах арга хэмжээ болон бүргэдийн дунд бүргэдээр шырга (хиймал ан) барилуулах тэмцээн, бүргэдээ хэрхэн сайн сургасан байдлыг шалгаруулах тэмцээн, Казах үндэсний тоглоом көкбэр (тулам булаалдах) тэмцээн, зоос шүүрэх тэмцээнүүдийг зохион байгуулна. Мөн "Морьтон баатруудын шоу тоглолт", "Шувуухуйн үзүүлбэр", "Шүхрийн үзүүлбэр" болон тойрон бүжиг, цаа буга, тэмээ, морь унах, бүргэд шувуу болон тэмээтэй зураг даруулах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдаа, урлагийн тоглолт зэрэг арга хэмжээг зохион байгуулж гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 13,000 гаруй хүн үзэж сонирхов.	100
480			5	"Монгол" өвлийн нүүдэлчин наадамьг зохион байгуулна.	2025-2028		120.0						120.0	Оролцогчид, тоо	100	300	-	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Засгийн газрын тохируулагч агентлаг Соёл, урлагын газар хамтран зохион байгуулахаар төлөвлөсөн ч Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн "Төвийн сахилга бат, хармуцлагыг чангатгах тухай" 05 дугаар албан даалгаврын хүрээнд арга хэмжээ цуцлагдсан.	
481			6	"Наурызын баяр " арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028		498.0						498.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	7000	8000	197.7	ЮНЕСКО-ийн хүн төрөлхтний соёлын биет бус өвийн жагсаалтад бүртгэгдсэн "Наурызын баяр"-ын өдрийг тохиолдуулан Казах түмний ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Баян-Өлгий аймгийн нутгийн зөвлөлтэй хамтран "Наурызын баяр-2026" арга хэмжээг 2026 оны 03 дугаар сарын 22-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулна. Арга хэмжээний үеэр Казах хувцастай иргэдийн баярын жагсаал, Казах түмний соёл, ёс заншил, ахуйг таниулсан гэр үзэсгэлэн, Казах түмний уламжлалт хоол, ундаа, жижиг дунд үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаа, Казах хувцастай гэр бүл, хос шалгаруулах тэмцээн, Күрэс бөхийн тэмцээн, Казахын уламжлалт наадтай Алты бахан /савлуур/ болон урлагийн тоглолт зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж, гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 20,000 гаруй хүн үзэж сонирхсон.	100
482			7	Суудлын авто машины ангиллын өвлийн мөсөн замын кроссын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулна.	2025-2028		75.0						75.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	300	400	-	Улаанбаатар хотод тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэмэгдүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор "WRX STI MEMBERS" авто холбоотой хамтран "Winter Time Attack" арга хэмжээг 2026 оны 03 дугаар сарын 07, 14-ний өдрүүдэд зохион байгуулна. Арга хэмжээнд нийт 3 клубын мэргэжлийн авто спортын 50 гаруй тамирчид 2 өдрийн турш өрсөлдөж шилдгүүдээ тодруулж, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 500 гаруй хүн үзэж сонирхлого.	100
483			8	"UB food" хоолны өдөрлөг арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028		2,720.0						2,720.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	35000	40000	355.5	Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, үндэсний болон олон улсын хоолыг олон нийтэд танилцан сурталчлах, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор "Улаанбаатар Фүүд Фестиваль 2026" арга хэмжээг 2026 оны 04 дүгээр сарын 17-26-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулав. Фестивальд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлдэг "Silk Road", "Asiana", "Bravo", "Dubbe haous", Маханд дуртай мангас, Арт гэр зэрэг 30 ААНБ, Бүгд Найрамдах Азербайжан Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улсаас мэргэжлийн тогооч нар хүрэлцэн ирж оролцсон бөгөөд нийт 18 улсын үндэстний хоолоор үйлчилсэн. Арга хэмжээний өдрүүдэд "Улаанбаатар театр" ын жран бүтээлчдийн тоглолт, амьд хөгжмийн тоглолт, хамтлаг, дуучид, уран бүтээлчдийн тоглолт болон DJ үзүүлбэр, Open Mic, Magic Mascot, хоолны шоу үзүүлбэр, үзэгчдийн дунд хөгжөөнт тэмцээн уралдаануудыг зохион байгуулж, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 108,000 гаруй иргэд жуулчид үзэж сонирхсон.	100
484			9	"Улаанбаатар травел" экспо зохион байгуулна.	2025-2028		117.0						117.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	2500	3000	-	"Улаанбаатар Аялал жуулчлалын холбоо"-той хамтран "Улаанбаатар травел экспо 2026" аялал жуулчлалын үзэсгэлэнг 2026 оны 05 сарын 29-31-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна. Тайлангах хугацаа болоогүй.	70
485			10	"Талын салхи" олон улсын мото наадамьг зохион байгуулна.	2025-2028		700.0						700.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	7000	8000	-	"Монголын чөлөөрчин ахан дүүс" ТББ-тай хамтран "Талын салхи-2026" олон улсын мото наадамьг 2026 оны 06 дугаар сарын 05,06-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбай болон "Говь-ресорт" цогцолборт зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна. Тайлангах хугацаа болоогүй.	
486			11	"Даншиг наадам-Иргэдийн баяр" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028		10,300.0						10,300.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	15000	20000	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдтэй хамтран "Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр-Хүрээ цам даншиг наадам 2026" арга хэмжээг 2026 оны 06 дугаар сарын 27, 28, өдрүүдэд Хүй долоон худгийн "Монгол наадам цогцолбор"-т зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна. Тайлангах хугацаа болоогүй.	
487			12	"Плэтайм" олон улсын амьд хөгжмийн наадамьг зохион байгуулна.	2025-2028		80.0						80.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	55000	60000	-	"Амьд хөгжмийн наадам" ТББ хамтран "Плэтайм" олон улсын амьд хөгжмийн наадамьг 2026 оны 07 дугаар сарын 02, 03, 04-ний "Плэтайм хүрээлэн"-д зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж байна. Тайлангах хугацаа болоогүй.	

488			13	"Дээлтэй Монгол наадам" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028		400.0			400.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	12000	13000	-	Ардын хувьсгалын 105 жилийн ой, Үндэсний их баяр наадмын хүрээнд Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамтай хамтран "Дээлтэй Монгол наадам" арга хэмжээг 2026 оны 07 дугаар сарын 09-ний өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна. Тайлагнах хугацаа болоогүй.	
489			14	"Даншиг наадам-Хүрээ цам" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028		3,330.0			3,330.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	25000	26000	-	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын бурхан шашинтны төв Гандантэгчэлчин хийдтэй хамтран "Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр-Хүрээ цам даншиг наадам 2026" арга хэмжээг 2026 оны 06 дугаар сарын 27, 28, өдрүүдэд Хүй долоон худгийн "Монгол наадам цогцолбор"-т зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна. Тайлагнах хугацаа болоогүй.	
490			15	"Хийморь" морьт харвааны олон улсын тэмцээн арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028		400.0			400.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	7000	8000	-	"Монголын Морьт Харваандын Холбоо"-той хамтран "Хийморь" олон улсын морьт харвааны тэмцээнийг 2026 оны 09 дугаар сарын 05,06-ны өдрүүдэд Чингис хааны хүрээ аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.Тайлагнах хугацаа болоогүй.	
491			16	"Улаанбаатар" олон улсын фото зургийн фестиваль зохион байгуулна.	2025-2028		80.0			80.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо		300	-	"Улаанбаатар" олон улсын фото зургийн фестиваль арга хэмжээг 2026 оны 09 дүгээр сарын 05-10-ны өдрүүдэд зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.Тайлагнах хугацаа болоогүй.	
492			17	"Ай Тм Эм" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулна.	2025-2028		90.0			90.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	4000	5000	-	"Монголын аялал жуулчлалын холбоо"-той хамтран "Ай Тм Эм" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг 2026 оны 10 дугаар сард зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна. Тайлагнах хугацаа болоогүй.	
493			18	Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын музейг сэргээгдэх эрчим хүчээр хангах барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.	2025-2028		3,200.0			3,200.0	Барилга, угсралтын ажлын явц, хувь	100	100	-	Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын музейн барилгын зураг, төсөв боловсруулах ажлыг "Ариосис" ХХК гүйцэтгэх магадлалын өрөнхий дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. Иймд барилга угсралтын ажлыг эхлүүлэх хугацаа хойшлогдсон болно.	50
494	3.4.2.Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.		1	Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчилж байгууллагуудын тоог нэмэгдүүлж замаар аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгана.	2025-2028						Бүтээгдэхүүн, үйлчилгээ, тоо	20	22	-	Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын улирлын хугацааг уртасгах, жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор "UB WINTER SALE" хөнгөлөлтийн аяныг зохион байгуулж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа соёл урлаг, аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний 52 аж ахуйн нэгж, байгууллага 100 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 5-70 хувь хүртэл хөнгөлөлт, урамшуулалттай үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүлнэ.	100
											Хамрагдсан байгууллага, тоо	80	90	-	"UB WINTER SALE" хөнгөлөлтийн аянд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа соёл урлаг, аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний 151 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан.	100
495	3.4.3.Худалдаа, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлхсөн явуулын үйлчилгээг бий болгож, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ	1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр олон улсын шинэ чанартай томоохон арга хэмжээнд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хамруулна.	2025-2028						Арга хэмжээнд хамруулсан жижиг, дунд бизнес эрхлэгчид, тоо	500	550	-	Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/01 дүгээр захирамжаар 2026 оныг "Бизнес эрхлэгчдийг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан гадаад, дотоодын иргэд, жуулчдад зориулан зохион байгуулсан Талын Жавхаа", "Улаанбаатарын өвлийн наадам", "Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль", "Бүргэдийн баяр", "Наурызын баяр", "Плейтайм пре эвент" хөгжмийн наадам, "UB food" олон улсын хоолны фестиваль зэрэг 7 арга хэмжээний үеэр 143 жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн худалдаа, үйлчилгээг гаргаж үйл ажиллагааг нь дэмжин ажилласан. Мөн Аялал жуулчлалын салбар, үндэсний үйлдвэрлэгчид болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Эдийн засаг хөгжлийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран "FEEL MONGOLIA-2026" арга хэмжээг 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулж, арга хэмжээнд үндэсний үйлдвэрлэгчид, үйлчилгээний бизнес эрхлэгчид, соёлын бүтээлч үйлдвэрлэл, эвент арга хэмжээ зохион байгуулагч байгууллагууд, ханган нийлүүлэгчид, зочид буудал, тур оператор зэрэг 250 гаруй аж ахуйн нэгж байгууллага, бизнес эрхлэгчид оролцон үйл ажиллагаагаа сурталчлан танилцууллаа.	72.1
496			2	Жуулчдад зориулсан төрөлжсөн худалдаа үйлчилгээний гудамж хэсгийг бий болгоно.	2025-2028		2,400.0				Тохижуулсан гудамж байршлын тоо		1	-	Жуулчны гудамжны тохижилтын ажил дууссантай холбогдуулан гадаад дотоод иргэд, жуулчдыг татах зорилгоор "Урт цагаан" үйлчилгээний төвтэй хамтран 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 9 дүгээр сарын 10-ныг хүртэлх хугацаанд худалдаа, үйлчилгээ бүхий жуулчны гудамж бий болгож Баасан, Бямба, Ням гарагуудад олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар төлөвлөж, нийслэлийн удирдлагуудад танилцууллаа.	30
497	3.4.4.Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, контент гадаад дотоодод түгээн сурталчилна.		1	Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчилна.	2025-2028		580.0				Эй Ар Би Ар (AR VR) дэвшилтэд технологийн бүтээсэн контент, тоо	2	3	-	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчлах ажлын хүрээнд мета куэст 3S төрлийн 11 ширхэг Би Ар (VR) төхөөрөмжөөр 32 бүтээгдэхүүн үйлчилгээнд VR 360 зураг авалт хийж, Web AR 3D модель контент хийсэн. Нэмэлтээр Улаанбаатар хотын 20 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээний Би Ар зураг авалтыг нэмж хийх, веб хуудаснаас үзэх боломжтой болгохоор програм шинэчлэлтийн ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.	50

498	3.4.5.Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.	Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.	1	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчилна.	2025-2028		2,150.0					Оролцсон олон улсын үзэсгэлэн, тоо	9	10	-	"Монголд зочлох жил"-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, тур оператор компаниудтай хамтран ХБНГУ-ын Берлин хотноо 2025 оны 03 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "ITB Berlin" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, Дэлхийн хотуудын аялал жуулчлалыг дэмжих байгууллага (TPO)-аас БНСУ-ын Бусан хотноо 2026 оны 05 сарын 11-14-ний өдрүүдэд зохион байгуулсан "TPO Capacity Building Program-2026" олон улсын арга хэмжээ, БНХАУ-ын Тианжин хотноо 2026 оны 05 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулсан "Улаанбаатар -Тианжин" хот хоорондын шууд нислэгийн нээлтийн арга хэмжээ зэрэг зэрэг олон улсын 3 үзэсгэлэн, арга хэмжээнд оролцож үйл ажиллагаагаа сурталчилсан.	30
499	3.4.6.Гадаад, дотоод хөлөл мэдээллийн байгууллагууд, дэлхийд алдартай аялагч, нөлөөлөгчдийг урин Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилна.		1	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад цахим орчинд нөлөө бүхий инфлюенсэрээр сурталчилна.	2025-2028		650.0					Олон улсад Сошиал орчинд нөлөө бүхий инфлюенсэрээр сурталчилсан	4	5	-	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг цахим сүлжээгээр олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 2026 оны 03 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд Чингис хааны хүрээ аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулсан "Бүргэдийн баяр" арга хэмжээг инфлюенс Т.Саруултөгс (Tushu Saruultugs)-өөр, жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан "Playtime" олон улсын хөгжмийн наадмын "Pre event" арга хэмжээг М.Ганбаяр инфлюенс (Gremix)-ээр, жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 оны 04 дүгээр сарын 17-26-ны өдрүүдэд зохион байгуулсан "УБ Фүүд фестивал" арга хэмжээг олны танил аялагч, судлаач Ц.Ган-елзэй (аяллын тойрог), Н.Энхбаяр (хоолондоо), Ч.Машнууцогч (Мангас машина-Meat-lover Monsters of Mongolia), мастер тогооч Ц.Мэнджаргал (Miko Miko) зэрэг нийт 7 нөлөөлөгчөөр дамжуулан 1 нэвтүүлэг, 8 удаагийн лайв, 31 удаагийн рийлс, 21 удаагийн пост мэдээлэл хийлгүүлж цахим орчинд түгээж, давхардсан тоогоор нийт 5,150,281 хүнд хүргэсэн байна.	100

Хэрэгжилтийн дундаж хувь 75,0

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:
НИЙСДЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА *Д.Батсүх* Д.БАТСҮХ

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, ГАНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН *О.Нямбат* О.НЯМБАТ

ҮНЭЛГЭЭ ХИМСЭН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН *Ч.Энх-Отгон* Ч.ЭНХ-ОТГОН

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИН

2026 оны 05 дугаар сарын 27

Улаанбаатар хот

2026 оны 05 дугаар сарын 27

№	Хүрэх үр дүн	Үр дүнгийн шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтот түвшин	Шалгуур үзүүлэлтийн тайлбар	Мэдээлэл цуглуулах давтамж	Зорилтот түвшинд хүрсэн эсэх (тоон утга)	Дүн (хувь)
				2025 он	2026 он				
ЗОРИЛТЫН ҮР ДҮН									
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО									
Аялал жуулчлал									
176	3.4.1.Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.	Арга хэмжээнд оролцогч, сонирхогч, жуулчин	тоо	70.000	80.000	Арга хэмжээнд оролцсон жуулчдын тоог нэгтгэж гаргана.	Жилд 1 удаа	163,200	100
177	3.4.2.Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагууд	тоо	80	90	Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх	Жилд 1 удаа	151	100
178	3.4.3.Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн явуулын үйлчилгээг бий болгож, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.	Арга хэмжээнд хамруулсан жижиг, дунд бизнес эрхлэгч	тоо	500	550	Арга хэмжээнд хамруулсан жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тоог гаргана.	Жилд 1 удаа	393	71.4
179		Жуулчдад зориулсан төрөлжсөн худалдаа үйлчилгээний гудамж, хэсэг	тоо	0	1	Дүүргүүдэд жуулчдад зориулан шинээр тохижуулсан гудамж, хэсэг	Жилд 1 удаа	1	100
180	3.4.4.Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, контент бэлтгэн, гадаад дотоодод түгээн сурталчилна.	Эй Ар Ви Ар (AR VR) дэвшилтэд тенхнологиир бүтээсэн контент	тоо	2	5	Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг нэмэгдүүлнэ.	Жилд 1 удаа	32	100
181	3.4.5.Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.	Оролцсон олон улсын үзэсгэлэн	тоо	9	10	Оролцсон олон улсын үзэсгэлэнгийн тоог нэмэгдүүлнэ.	Жилд 1 удаа	3	30

182	3.4.6.Гадаад, дотоод хэвлэл мэдээллийн байгууллагууд, дэлхийд алдартай аялагч, нөлөөлөгчдийг урин Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилна.	Инфлюнсэрээр сурталчилсан сурталчилгаа	тоо	4	5	Сошиал орчинд олон улсад нөлөө бүхий инфлюнсэр оролцуулан Улаанбаатар хотыг сурталчилна.	Жилд 1 удаа	7	100
Нэгдсэн дүн (хувь)									85.91

ХЯНАЖ, ТАНИЛЦСАН:
НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА Д.БАТСҮХ

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСҮЙН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН О.НЯМБАТ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД
АЖИЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН Ч.ЭНХ-ОТГОН